



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2024.06.07 № 1/369  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хандивын тайлангийн маягт  
хүргүүлэх тухай**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37.7-д “Нам, эвсэл нь орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө энэ хуулийн 25.3.6, 25.4.6-д заасан хандивын тайландаа дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасан.

Энэхүү чиг үүргээ хэрэгжүүлэхээр “Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргах заавар”-ыг Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/47 дугаар тушаалаар баталсан.

Нам, эвсэл бие даан нэр дэвшигч Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37.7-д заасан хандивын тайланг “Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт зааврын хавсралт МАЯГТ 1, 2-ын дагуу 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 23:59 цагийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлнэ.

Хандивын тайланг үнэн зөв, холбогдох мэдээллийг бүрэн тусгасан байдлаар хуульд заасан хугацааны дотор, дүгнэлт гаргахад шаардлагатай дараах баримт бичгийг нотлох баримтын шаардлага хангасан хэлбэрээр битүүмжлэн ирүүлнэ үү.  
Үүнд:

- Намын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Намын 2023 оны санхүүгийн жилийн эцсийн аудитлагдсан тайлан;
- Харилцагч банкны баталгаажуулсан дансны хуулга (2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх)
- Банкны тодорхойлолт (данс бүрээр)

Бие даан нэр дэвшигчийн хувьд Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшин хандивын данс нээлгэж, бүртгүүлсэн дансанд дээр дурдсан хугацаанд хандив авсан бол дүгнэлт гаргуулна.

5020441


Нам, эвслээс дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд аливаа байдлаар тусгагдаагүй орхигдсон эсхүл мэдээлээгүй хандивыг төрийн аудитын газар хариуцахгүй болно.

Жич: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 7044-2424 дугаарын утсаар холбогдож лавлагаа мэдээлэл авах боломжтой бөгөөд дансны хуулга, МАЯГТ 1,2-г EXCEL хэлбэрээр Bayankhongor@audit.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

Хавсралт.....хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ



Дарга, тэргүүлэх аудиторын  
 2024 оны 06 дугаар сарын 07-ны  
 өдрийн тоот алба бичгийн хавсралт  
 Маягт-1

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэлд "Иргэн"-ээс өгсөн хандивын тайлангийн маягт  
 ..... /намын нэр/

6417143544  
 БЧ040067 9007 /мян.төг/

Д/д	Иргэний овог нэр	Хандив өгсөн иргэний мэдээлэл				Хандив өгсөн огноо	Хандивын мөнгөн дүн	Хандив хүлээн авсан		Тайлбар
		Регистрийн дугаар	Нас	Оршин суугаа хаяг	Утасны дугаар			Банкны нэр	Дансны дугаар	
<b>2023 оны 01 дүгээр сарын 01-с 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон нь.</b>										
							-			
<b>2024 оны 01 дүгээр сарын 01-с 06 дугаар сарын 01 -ний өдөр хүртэл</b>										
							-			

**Санамж:** Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-т заасан иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивт намын дүрэм, дотод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан өгсөн хандивыг хамруулахгүй.

Тамга, тэмдэг

/тухайн намын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, албан ёсны тамга тэмдэгээр баталгаажуулна./

.....  
 албан тушаал

.....  
 овог, нэр

/...../  
 гарын үсэг

Дарга, тэргүүлэх аудиторын  
 2024 оны 06 дугаар сарын 07-ны  
 өдрийн 2024/06/07 тоот албан бичгийн хавсралт  
 Маягт-2

6417143544  
 84040067 9007423

**Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэлд "Хуулийн этгээд"-ээс өгсөн хандивын тайлангийн маягт**

..... /намын нэр/

Д/д	Иргэний овог нэр	Хандив өгсөн иргэний мэдээлэл				Хандив өгсөн огноо	Хандивын мөнгөн дүн	Хандив хүлээн авсан		Тайлбар
		Регистрийн дугаар	Нас	Оршин суугаа хаяг	Утасны дугаар			Банкны нэр	Дансны дугаар	

**2023 оны 01 дүгээр сарын 01-с 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон нь.**

1										
2										
3										

**2024 оны 01 дүгээр сарын 01-с 06 дугаар сарын 01 -ний өдөр хүртэл**

1										
2										
3										
4										

**Санамж:** Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-т заасан иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивт намын дүрэм, дотод зохион байгуулалтын үйл ажиллагаанд зориулан өгсөн хандивыг хамруулахгүй.

Тамга, тэмдэг

/тухайн намын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, албан ёсны тамга тэмдэгээр баталгаажуулна./

.....  
 албан тушаал

.....  
 овог, нэр

/...../  
 гарын үсэг